



*Empowered lives.
Resilient nations.*

**ШУТИС-ын ГУУС ДЭЭР ЗОХИОН БАЙГУУЛСАН
“ХАРИУЦАГАТАЙ УУЛ УУРХАЙ” СЭДЭВТ, СУРГАГЧ БАГШ
БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ТАЙЛАН**



2017 он 1 сар

**ШУТИС-ын ГУУС ДЭЭР ЗОХИОН БАЙГУУЛСАН
“ХАРИУЦАГАТАЙ УУЛ УУРХАЙ” СЭДЭВТ, СУРГАГЧ БАГШ
БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ТАЙЛАН**

Сургалтын зорилго

Энэхүү сургалтын зорилго нь хариуцлагатай уул уурхайн сургалтанд хичээл заах багш нарыг бэлтгэх сургалт юм. Энэ удаагийн сургалтаар сургагч багш нарт онолын мэдлэг олгоно. Мөн гарын авлагад мэргэжлийн зүгээс техникийн редакц хийх хэмжээнд хэлэлцүүлгийг бүлгийн ажлын хүрээнд хийж гарын авлагыг хэвлэхийн өмнөх түвшинд хүргэх зорилготой.

Сургалт зохион байгуулсан талаар

Сургагч багш нь дараах шаардлагыг хангасан байх хэрэгтэй байдаг:

1. Уул уурхайн чиглэлийн мэргэжилтэй байх
2. Багшлах туршлага дадлагатай байх
3. Хариуцлагатай уул уурхайн чиглэлээр ажиллаж, энэ мэдлэгийг нийтэд түгээн дэлгэрүүлэх үйлсэд оролцох хүсэлтэй байх.

Дээрх шаардлагыг хангах хүн олдох нь манайд жаахан хүндрэлтэй асуудал байсан. Хэрэв дээрх 3 шаардлагын эхний хоёр шаардлагын аль нэгийг нь хангаагүй хүнийг багшаар бэлдэх нөхцөлд, багшийг дээрх нөхцөлийг хангуулахын тулд нилээд удаан хугацааны хүч хөдөлмөр зарцуулан, сургах шаардлага гарна.

Харин бидний энэ хэрэгжүүлж буй төсөл нь хязгаарлагдмал хөрөнгөөр их ажил амжуулах шаардлага гарсан байсан тул бид хамгийн бага зардлаар, чанарын шаардлага хангасан багш бэлдэх эрэлд гарсны дүнд ШУТИС-ын ГУУСургуультай хамтарч ажиллаж, энэ асуудлыг шийдвэрлэх боломжтой юм гэсэн шийдэлд хүрсэн.

Зорилгоо хэрэгжүүлэх үүднээс манай ТББ нь Геологи уул уурхайн сургуулийн Уул уурхайн салбартай хамтарч ажиллах гэрээг салбарын эрхлэгч Хавалболаттай байгуулж, цаашид хамтран Хариуцлагатай уул уурхайн сургалтыг зохион байгуулж, улмаар ХУУ-н стандартыг боловсруулахаар ажиллаж байна.

Сургалтыг ШУТИС-ийн 2-р байрны 215 тоот өрөөнд 2017 оны 2-р сарын 18-нд зохион байгууллаа.

Суралцагсдын бүрэлдэхүүнд Геологи уул уурхайн сургуулийн уул уурхайн салбарын уурхайн ашиглалтын багш 2, ашигт малтмалын баяжуулалтын багш 3, уул уурхайн машин тоног төхөөрөмжийн багш 2, уулын цахилгааны багш 1, уул уурхайн менежментийн багш 1, уурхайн ашиглалтын инженер 1, уурхайн машин тоног төхөөрөмжийн инженер 1, уул уурхайн менежментийн төгсөх курсын оюутан 2 нийт 13 хүн оролцлоо

Сургалтанд оролцсон хүмүүсийн бүртгэлийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Суралцагчийн нэр	Албан тушаал	Утас, Мэйл хаяг
1	Г.Зулзаяа	Баяжуулалтын багш	99029150, zulzaya@must.edu.mn
2	Д.Далайцэцэг	Баяжуулалтын багш	99060756 dalaitsetseg@must.edu.mn
3	Б.Улаанбаатар	Уурхайн ашиглалтын багш	99021381 ulaanbaatar888@must.edu.mn
4	Ч.Болормаа	Баяжуулалтын багш	99120022 chbolor@must.edu.mn
5	Ч.Зэндмэнэ	Уурхайн машин тоног төхөөрөмжийн багш	88011077 zendmene@must.edu.mn
6	С.Эрдэнэцэцэг	Уулын цахилгааны багш	96016366 erdenetsetseg_s@must.edu.mn
7	Д.Батбаяр	Уурхайн ашиглалтын багш	99912688 dashnyam_batbayar@must.edu.mn
8	Г.Энхжаргал	Уурхайн машин тоног төхөөрөмжийн багш	99892989 g.enkhjargal@must.edu.mn
9	Х.Дашдондог	Уурхайн менежментийн багш	99134456 dashdondog@must.edu.mn
10	Б.Амгаланбаяр	Салбарын эрхлэгчийн туслах, уурхайн ашиглалтын инженер	95530099 amgаланbayar@must.edu.mn
11	Ч.Билгүүн	ШУТИС уул уурхайн менежмент 4-р курсын оюутан	99253464 belka_nar@yahoo.com 2 дахь удаагаа сургалтанд хамрагдаж байгаа
12	Х.Гэрэлтуяа	ШУТИС уул уурхайн менежмент 4-р курсын оюутан	88449249 x.boroo@yahoo.com
13	Г.Ганбилэг	Уул уурхайн механик инженер	94442525 2 дахь удаагаа сургалтанд хамрагдаж байгаа

Тус сургуулийн уул уурхайн салбар нь нийт 42 багштай. Уул уурхайн ашиглалт, баяжуулалт, менежмент, уулын цахилгаан болон машин тоног төхөөрөмжийн инженер бэлтгэдэг. Эндээс зөвхөн өөрсдийх нь хүсэл, сонирхолд тулгуурлаж 10 багшийг сургагч багшаар бэлтгэх санал өгсөн боловч 12 багш оролцох хүсэлтээ ирүүлсэн ба тухайн сургалтанд 2 багш нь өөр газар хичээл давхцаад ирж чадаагүй.

Иймд сургагч багшийн сургалтанд хамрагдсан хүмүүс сургагч багш болох өөрийн хүсэлтээр хамрагдаж байгаа бөгөөд тэд 8-20 жил багшилж байгаа хүмүүс байсан тул, заах аргын боломжийн хэмжээнд туршлагатай бөгөөд заах хичээлийг хурдан эзэмших боломжтой нь сургалтанд болон хэлэлцүүлэгт оролцож байгаа байдлаас харагдаж байсан.

Багш нарт сургалтын гарын авлагыг 2 долоо хоногийн өмнө файлаар өгсөн байсан тул тэд сургалтын үед гарын авлагаа хэвлээд аваад ирчихсэн, хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож байснаас харагдаж байсан. Зааж байгаа зүйлсийг

тэдний хүлээн авч байгаа байдал, тавьж буй асуултаас нь харахад ХУУ-н хөтөлбөрт тусгагдсан хичээлийг заах, чадварлаг сургагч багш нар болж чадна гэдэгт итгэл төрсөн. Тэдний дунд Баянхонгорын нэг багш байсан бөгөөд Баянхонгорын сургалтанд хамт явж эхний ээлжинд мэргэжлийн хичээлүүдийг орохоо илэрхийлсэн. Цаашид багш нарыг сургалтуудад ээлжлэн авч явж ХУУ-н зарчмуудын тухай хичээлүүдийг заалгаж, хичээлийн сэдвүүдийг эзэмшүүлэх ажил хийх нь зөв гэж үзсэн.

Гарын авлагын хэлэлцүүлэг хийсэн талаар.


Гарын авлагын хэлэлцүүлэгт багш нар идэвхтэй оролцсон. Тэдний талаас олон үнэтэй санал гарсан ба багш нар нарийвчлан засахад цаг их орохоор байсан тул хуваан авч дараа тухтай нарийн засвар хийгээд, цагаан сарын өмнө амжуулж өгөхөөр тохиролцон, үүрэг аваад тарсан. Багш нартай хийсэн хэлэлцүүлэг, ярилцлагын үеэр гарсан саналуудын талаар тоймилон бичихэд:

1. Удиртгал хэсэгт Шарын голын уурхайн тухай авсан жишээг оновчгүй байдлаар илэрхийлсэн тухай.
2. Зарим хэллэг нь номны хэллэг биш хэт энгийн хүүрнэх байдлаар бичсэн тухай
3. Зургийн тайлбарыг үйл үгээр төгсгөдөггүй тухай
4. Зургийн тайлбарт “Зураг 1” гэж бичдэггүй “1 дүгээр зураг” гэж бичдэг тухай
5. “Уул уурхай эрхлэгч” гэдгийг өөр оновчтой үгээр солих тухай
6. Эрлийн ажлын ангиллыг хоёр удаа давхардуулан оруулсан тухай
7. “Геологи хайгуул”, “гоеологи судалгаа” гэж бичсэнүүдийг “геологийн судалгааны ажил” гэж засах тухай
8. Бүлгийн дугаарлалтуудыг цэгцлэх г.м асуудлуудыг ярьж байгаад номны 1-р хэсгийг Зулзаяа ахлаад Далайцэцэг, Болормаа, Амгаланбаяр нар, 2-р хэсгийг Зэндмэнэ, 3-р хэсгийг нь Дашдондог хариуцаад Нандинцэцэгийн хамт нарийвчлан засаад цагаан сарын өмнө амжуулан өгөхөөр тохиролцов.

Сургалтын үр дүн дүгнэлт.

1. Геологи уул уурхайн сургуулиас хамрагдаж байгаа 10 багш мэргэжлийн хичээлийг заахад бүрэн бэлтгэлтэй бэлэн байгаа бөгөөд ХУУ-н хэсгийн материалыг эзэмшээд, хичээл заахад ямар нэг хүндрэл байхгүй тухайгаа илэрхийлсэн, мөн манай талаас үүнд итгэлтэй байна. Харин гаднаас оролцсон 3 хүн сургалтуудад байнга оролцон, дадлагажиж, сургагч багш болохоор өөрсдийн сонирхлоор ажиллаж байгаа тул манай байгууллага багшлах боловсон хүчний тодорхой нөөцтэй болж чадлаа гэж дүгнэж байна.
2. Аливаа ажил бүтээлийн алдааг олж засах нь багш нарын нэг мэргэжил болсон зүйл байдаг тул номын редакци сайн хийгдэнэ гэдэгт итгэлтэй байна

Тогтвортой хөгжлийн төлөөх хариуцлагатай уул уухайн санаачилга ТББ



**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ
УУЛ УУРХАЙН САНААЧИЛГА ТББ**